

Батлав.с.м.....

2-р ангид заах Математикийн ээлжит хичээлийн хөтөлбөр

Хичээлийн сэдэв: 6-гийн хүрд

Зорилго: -Өмнөх мэдлэгт тулгуурлан 6-гийн хүрдийг зохиох

-“найзаа олох” тоглоом тоглонгоо сурах

-цагаан сараар буузаа хялбар тоолж сурах арга эзэмшүүлэх

Хичээлийн явц:

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	хугацаа
өмнөхийг сэргээх	-Сурагчдад хүрдний үржвэр ба дүнг бичсэн хэрчмэл тараах материал өгнө. -Үржвэр бичсэн болон дүн бичсэн материал тус бүр сурагчдын тоогоор хос хосоороо байна. -Найзаа олох тоглоомын дүрмээ сэргээн хэлж өгнө.	Сурагчид өгсөн тараах материалыг авч үржвэр авсан нь самбарын урд, хүрдний дүн авсан нь хойноо гарч зогсоно. Нэг сурагч 5 ба 4-ийн үржвэр гэхэд дүнг авсан сурагч би чиний найз байна гээд хамт суудалдаа очиж сууна. Энэ мэтээр бүх сурагч 2,2-оороо сууж дуусна.	
Шинэ мэдлэг олгох	Ой тогтоолтын дасгал Хэдэн дүрс зөв зурснаа тоолоод үнэлгээ тавина. -цагаан сарын буузаа хичнээн болсныг яаж тоолдог вэ? Тавиур дээр хэдэн бууз байна вэ? Яаж тоолсон бэ? Бодолт хийгээрэй.	Самбарт тавьсан зургийг 1 минут ажиглаад тогтоосон дүрсээ дэвтэртээ зурна. -буузыг тоолоод хэлнэ. 6,12,18.....гм 10 эгнээ хүртэл тооцоолон бодолт хийнэ.	
Батагдал	Хоосон нүдэнд ямар тоо байх вэ? $6 \times 3 =$ ижил нэмэгдэхүүний нийлбэр болгоорой. Цээж бодолт хийгээрэй үгэн таавар олоорой өгүүлбэртэй бодлого уншаад, өөрсдөө бодно. Товч бичиглэл хийлгэнэ. “өгсүүр өөд гялс “ жишээ бодуулна.	12,18, 24,?,? $6 + 6 + 6 + 6 + 6 =$ 6-гийн хүрд, байр сэлгэх хууль, тоог 1-д хуваах Гэрийн зураг л үсэг –гэрэл, Сарны зураг н үсэг-Саран Нарны зураг н үсэг- Наран -Гэрэл 6 мод, Саран түүнээс 2 дахин их мод тарив. Хоёр хүүхэд хэдэн мод тарьсан бэ? -Гэрэл-6 Саран-? 2 дахин их $6 \times 2 = 12$ $6 + 12 = 18$ өгсөн жишээг бодоод өөрсдөдөө оноо үнэлгээ тавина.	
Гэрт	Хуудас 96		

Батлав.с.м.....

2-р ангид заах Математикийн хичээлийн конспект

Хичээлийн сэдэв: 6,7-гийн хүрдний бататгал

Зорилго: -Өмнөх мэдлэг чадварыг сэргээн бататгах

-мэдлэгийг гүн бат эзэмшүүлэх

-хүрд тогтоох чадварыг нэмэгдүүлж хэрэглээ болгох

-үржвэрийг нэмэгдэхүүн болгон задлах

-сэтгэхүйг хөгжүүлэх

Хичээлийн явц:

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	хугацаа
өмнөхийг сэргээх	-Сурагчдад хүрдний үржвэр ба дүнг бичсэн хэрчмэл тараах материал өгнө. -Үржвэр бичсэн болон дүн бичсэн материал тус бүр сурагчдын тоогоор хос хосоороо байна. -6,7-гийн хүрд оролцсон үржвэр ба дүн байна. -Найзаа олох тоглоомын дүрмээ сэргээн хэлж өгнө.	Сурагчид өгсөн тараах материалыг авч үржвэр авсан нь самбарын урд, хүрдний дүн авсан нь хойноо гарч зогсоно. Нэг сурагч 7 ба 6-ийн үржвэр гэхэд дүнг авсан сурагч би чиний найз байна гээд хамт суудалдаа очиж сууна. Энэ мэтээр бүх сурагч 2,2-оороо сууж дуусна.	
Бататгал	Ой тогтоолтын дасгал Хэдэн дүрс зөв зурснаа тоолоод үнэлгээ тавина. Хоосон нүдэнд ямар тоо байх вэ? $7 \times 4 =$ ижил нэмэгдэхүүний нийлбэр болгоорой. Цээж бодолт хийгээрэй үгэн таавар олоорой өгүүлбэртэй бодлого уншаад, өөрсдөө бодно. Товч бичиглэл хийлгэнэ. “өгсүүр өөд гялс “ жишээ бодуулна.	Самбарт тавьсан зургийг 1 минут ажиглаад тогтоосон дүрсээ дэвтэртээ зурна. 14,21, 28 , ?, ? $6+6 +6+6+6+6+6=$ 6-гийн хүрд, байр сэлгэх хууль, тоог 1-д хуваах Цэ. 60гал, нар.ан -ээж 7 алим авав. Хүү түүнээс 5 дахин их алим авсан бол энэ хоёр хамтдаа хэдэн алим авсан бэ? өгсөн жишээг бодоод өөрсдөдөө оноо үнэлгээ тавина.	
Гэрт	Хуудас 102		

Батлав.с.м.....

Математикийн ээлжит хичээлийн хөтөлбөр

2012-11-16

Заах анги: 2-р анги

Хичээлийн сэдэв: Оёдолчинд тусалцгаая

Зорилго: -Өмнөх мэдлэгт тулгуурлан 7-гийн хүрдийг бүтээх

Зорилт: - Монгол үндэсний дээлийн тухай мэдлэгийг өргөтгөх

- Ижил нэмэгдэхүүний нийлбэрийг үржвэр хэлбэрт оруулан 7-ийн хүрдийг бүтээх
- Үржвэрийг нийлбэр хэлбэрээр бичих
- 7-гийн хүрдээ ашиглан асуудал шийдвэрлэх

Хичээлийн явц:

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	хугацаа
Анги зохион байгуулалт, Өмнөхийг сэргээх	-Сурагчдад хүрдний үржвэр ба дүнг бичсэн хэрчмэл тараах материал өгөөд “Найзаа олох” тоглоомын дүрмээ сэргээн хэлж өгнө.Жишээ нь: 4х6 –г авсан сурагч “Энэ хэд вэ?” гэж асуухад 24 –г авсан сурагч “Би найз чинь байна.” гэж бие биеэ олоод хамтдаа ширээнд сууна. .	Найзаа олох тоглоомын дүрмээр бүх сурагчид 2,2-оороо суудлаа эзэлж сууна. .	5минут

Сэдэлжүүлэлт	- Багш нь та нарт нэг зүйлийг үзүүлье. Юу байгаа гэж бодож байна. /Багш далдаас гялгар уутны чимээ гаргаж дээлээ гаргана./ -Дээл гаргаж ирнэ.7 товчтой дээл байна. Товч нь дутуу дээлний зургийг хүүхдүүдэд тарааж өгнө. Зураг болон дээлний зургийг харьцуулан ажиглаарай. Юу нь дутуу байна вэ? -Дээлийг хэн оёдог вэ? - Товчийг гүйцээж хадахад бүгдээрээ “Оёдолчинд тусалъя.” -Самбарт “Оёдолчинд тусалцгаая.” гэсэн гарчгийг тавина	-Сурагчид чихэр, ном, тоглоом гэх мэт янз бүрийн хариулт хэлнэ. Хариултын тоог 5-аас илүүгүй байхаар тооцно. Товч нь дутуу байна. -Оёдолчин оёно	5 минут
---------------------	---	---	----------------

Шинэ мэдлэг бүтээх үе	- Нэг дээлэнд хэдэн товч хадах вэ? Ширээн дээр хүүхдүүдэд тарааж өгсөн дээлний зураг дээр товчоо зурна. Түрүүлж зурсан нэг хүүхдийн зургийг самбарт тавьж, товчоо тоолно. - Тэгвэл нэг дээлэнд 7 товч байгааг яаж бичих вэ? - Хэн самбарт бичих вэ? - Нэг дээл 7 товчтой юу? 7 дээл 1 товчтой юу? - Аль бодолт нь зөв байна вэ? - Нэг нь юуг илэрхийлж байна? - Долоо нь юуг илэрхийлж байна вэ? - Тэгвэл 2 дээл оёход оёдолчинд хэдэн товч хэрэгтэй вэ? гээд бичвэрийн өмнө жижиг дээлний загварыг нааж өгнө. - Тэгвэл 3,4,5 дээл оёход оёдолчинд хэдэн товч хэрэгтэй вэ? гэх мэтээр 10 дээл оёход хэдэн товч хэрэгтэйг тооцоолоорой гэнэ. Энэ үед дээлний жижиг загвар хамт наагдаж байна.	7 товч Хүүхдүүд дэвтэрт бичнэ. Хариулт 1: $7 \times 1 = 7$ Хариулт 2: $1 \times 7 = 7$ Нэг дээл 7 товчтой $1 \times 7 = 7$ товч Тоо ширхгийг Товчний тоог $7 + 7 = 2 \times 7 = 14$ хүүхдүүд энэ бичиглэлийг дэвтэрт хийж явах ба нэг нэгээрээ гарч самбарт бичиглэлийг бичнэ. Хүүхдүүд дэвтэр болон самбарт бичиж явна. $7 + 7 + 7 = 3 \times 7 = 21$ $7 + 7 + 7 + 7 = 4 \times 7 = 28$ $7 + 7 + 7 + 7 + 7 = 5 \times 7 = 35$ $7 + 7 + 7 + 7 + 7 + 7 = 6 \times 7 = 42$ $7 + 7 + 7 + 7 + 7 + 7 + 7 = 7 \times 7 = 49$ $7 + 7 + 7 + 7 + 7 + 7 + 7 + 7 = 8 \times 7 = 56$ $7 + 7 + 7 + 7 + 7 + 7 + 7 + 7 + 7 = 9 \times 7 = 63$ $7 + 7 + 7 + 7 + 7 + 7 + 7 + 7 + 7 + 7 = 10 \times 7 = 70$	15 минут
-----------------------	--	--	----------

Батагтал бие даалт	- За хүүхдүүдээ та нар оёдолчинд тусалж чадлаа та нарт талархлаа илэрхийлээд дахин нэг бодлого бодоод өгөөч ээ гэжээ. - Хүүхдийн дээлэнд 5 товч ордог бол тийм 7 дээлэнд хэдэн товч хадах вэ? - Сайн байна. 7x5 Энэ тохиолдолд нэгдүгээр үржигдэхүүн нь юуг илэрхийлж байна. Хоёрдугаар үржигдэхүүн нь юуг илэрхийлж байна? - Сайн байна. Бид оёдолчинд дахин тусалж чадлаа.	Сурагчид анхаарлаа хандуулна. Хүүхдүүд дэвтэртээ бодлогыг бодно. Самбарт гарна. $5+5+5+5+5+5+5=7 \times 5=35$ товч $5 \times 7=35$ 7 бол тоо ширхгийг 5 нь ижил нэмэгдэхүүнийг илэрхийлнэ. Хүүхэд урамшина.	5 минут
Үнэлгээ Дүгнэлт	- Үйл ажиллагаа бүрт багш стандарт бус үнэлгээг хэрэглэж, дэмжих, урамшуулах буюу хүүхдийн дэвтэрт хяналт тавьж явна. - “Оргилд бүгдээрээ гарцгаая ” дидактик тоглоомыг тоглуулна. Тоглоомыг хавсаргав. - Хүрдийг самбараас дахин уншуулж хичээлээ дүгнэнэ:	Ширээнд сууж буй хос сурагчид шатны 2 талаас өгөгдсөн үржвэрийг бодоод оргилд хүрэхэд зэрэг бодож дууссан байх шаардлагатай. Түрүүлж бодсон хосыг багш нэрлэж, урамшуулах замаар бодлогыг дүгнэж дуусна.	5 минут

Хөтөлбөр бол

Боловсруулсан: Булган бүсийн “Математик-Бага” баг

Багийн гишүүд: Д. Энхцэцэг

Ц. Уранцэцэг

Д. Энхтулга

С. Адьяа

Ж. Алтанхуяг

Э. Батаа

Д. Болормаа

О. Батцэцэг

Ж. Бямбасүрэн

Б. Дашдаваа

Б. Даваамаа

Л. Туул

Л. Хишигдэлгэр

Хичээл заасан багш С. Дэлгэрмаа

Хамтран ажилласан: Б. Золзаяа, Д. Гантуяа, Э. Болорчимэг

Самбар төлөвлөлт:

